



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/94

Бөхт

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7, 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Нэгдсэн халаалтын өргөтгөл хийх” ажлын зураг төсвийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч	Л.Мөнхбадрах	(Засаг даргын орлогч)
Гишүүд	Б.Нарандэлгэр	(Газрын даамал)
	О.Амгалантөр	(Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Зураг төслийг ажлын даалгаврын дагуу нягтлан хянаж, хүлээж авахыг ажлын хэсэг (Л.Мөнхбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ